

Научная статья

УДК 821.512.36.0

DOI 10.18101/3033-1310-2025-2-82-93

Д. Цэнджавын туужуудын төрөл зүйлийн асуудлууд

© **Пурэвсүрэнгийн Яндий**

доктор (Ph.D), утга зохиолын багш

Нийгэм, хүмүүнлэгийн дээд сургууль,

Монголын Улсын боловсролын их сургууль

Монгол Улс -14. Сүхэ-Батор дүүрэг, Улаанбаатар-14191

yandii@msue.edu.mn

Хураангуй. Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, МЗЭ болон Д. Нацагдорж, С. Буяннэмэхийн шагналт Долгорын Цэнджав // Утга зохиол судлал шинжлэл. 2017. Дугаар 7 монголын хүүрнэл зохиолын төрөлд өөрийн гэсэн байр сууриа эзэлсэн уран бүтээлчийн нэг юм. Тэрбээр шинэ зуун гаснаас хойш цөөнгүй тууж туурвисан бөгөөд 2014 онд “Хөх жавар” /1995/, “Тэнгэрт хальсан тоос” /2014/, “Өнцөгдсөн сэнтий” /2013/, “Цахарын хар шуурга” /2007/, “Гүн тайгын манан” /1996/, “Тал сар” /2014/, “Маргааш л дайн эхэлчих юм шиг 1080 хоног минь” /2007/ гэсэн туужуудаас бүрдсэн түүврээ хэвлүүлэн олны хүртээл болгоод чамгүй хугацаа өнгөрчээ. Эдгээр туужаас манай эрдэмтэн, судлаачдын” (доктор Б. Хишигсүх, доктор П. Батхуяг, доктор Ч. Чимэгбаатар, доктор П. Яндий...) хараанд өртөж чамгүй магтаал сайшаал хүртсэн бүтээлийн нэг нь “Хөх жавар тууж юм. 2016 онд судлаач Ч. Чимэгбаатар “Хоёр туужийн туурвил зүйн онцлог” гэсэн сэдвээр шүүмж судлалын өгүүлэл бичиж, үүндээ “Хөх жавар”, “Тэнгэрт хальсан тоос” туужийн бичлэгийн хэв маягийг нь тодорхойлж, санал дүгнэлтээ дэвшүүлсэн байдаг. Бид энэ удаа эрдэмтэн, зохиолч Д. Цэнджавын туужуудын төрөл зүйлийн онцлогийг тодруулахаар зорьсон юм.

Түлхүүр үг: төрөл зүйл, сэтгэл зүйн тууж, түүхэн тууж, эссэ тууж, дүр.

Для цитирования

Пурэвсүрэнгийн Я. Д. Цэнджавын туужуудын төрөл зүйлийн асуудлууд // Буряд хэлэн болон уран зохёол хургуулида. 2025. Дугаар 2. Н. 82–93.

Үндсэн хэсэг. Тууж гэж юу вэ? туужид юуг, хэрхэн? яаж? дүрсэлж үзүүлэх, бичих талаар эрдэмтэн, судлаач Ши. Цэнд-Аюуш “Монгол тууж” ганц сэдэвт бүтээлдээ: “*Туужид нийгмийн амьдралын аль нэгэн талыг тодорхойлон, хэсэг хүний үйл амьдралын тодорхой үйл явдал буюу гол баатрын амьдралын замнал хувиралт өөрчлөлтийг үзүүлсэн холбоо уялдаа бүхий хэд хэдэн үйл явдлыг нэгтгэн өгүүлдэг байна. Тодруулж хэлвэл, тууж гэдэг нь нийгмийн үзэгдэл байдал, хүмүүсийн үйл амьдралыг романд тусгаснаас бага, өгүүллэгт тусгаснаас их хэмжээгээр дүрслэн үзүүлдэг үргэлжилсэн үгийн зохиолын дундач төрөл зүйл юм.*” // Монгол тууж. 1981. Дугаар 7-8 хэмээн тодорхойлсон байдаг. Туужийн дотоод төрөл зүйлийг дотор нь адал явдалт тууж, уран зөгнөлт тууж, хошин шог тууж уянгын тууж, ёс суртахууны тууж, намтарчилсан тууж, түүхэн тууж, сэтгэл зүйн тууж, баатарлаг явдлын тууж, баримтат тууж, эссэ тууж зэрэг болно. Эдгээр туужийн төрөлд зохиолч Д. Цэнджавын ямар туужууд нь багтаж болохыг дараах байдлаар авч үзлээ.

Сэтгэл зүйн тууж: Сэтгэл зүйн туужийг тодруулан авч үзвэл бусад төрөл зүйлийн нэгэн адил байгалийн байдал, хүний сэтгэлийн хөдлөл, үйл явдлын онцгой нэг явдалд төвлөрч, гадаад ертөнц, юмс үзэгдлийн мөн чанарыг сэтгэлийн дотоод үйлчлэлийн хүчээр илэрхийлэхдээ хүний санаа сэтгэлийн ертөнцийн уярал, догдлол, бодол санааны төлөв байдалтай хослуулан гаргадаг. Ингэхдээ аливаа үйл явдалд дасан зохицож буй баатруудын сэтгэл зүйн зөрчил тэмцлийг дүрийнхээ дотоод сэтгэл зүйтэй хослуулан нээн харуулдаг өвөрмөц төрөл юм. Тиймээс сэтгэл зүйн өнгө аястай ямар ч зохиолыг уншиж байхад хүний сэтгэлийг жихүүцүүлэн огшуулж, айдас хүйдэс төрүүлж, харамсал гашуудал, гэмшил ухаарлыг нэгэн зэрэг огшуулж байдаг бөгөөд бид энэхүү өвөрмөц өнгө аяст тулгуурлан Д. Цэнджавын дараах туужуудыг сэтгэлзүйн туужид багтаан авч үзлээ. Жишээ нь: “Хөх жавар” /1995/ тууж нь олны хүртээл болоод цөөнгүй хугацаа өнгөрчээ. Туужийг уншиж байхад хүний сэтгэлийг жихүүцүүлэн огшуулж, айдас хүйдэс төрүүлж, харамсал гашуудал, гэмшил ухаарлыг нэгэн зэрэг огшуулж байдаг. Үүний учир нь хүн чанарын асуудлыг дүрийнхээ дотоод сэтгэл зүйтэй хослуулан нээн харуулж чадсан туурвил зүйн онцлогтой нь холбоотой юм.

Туужид Хар ховч овогт дөрвөн үе дамжсан хараалч онгоны удамтай Харлаг Доной гэгч эцэг “Хөх цавьт”-аас дом шившлэгийн элдэв зүйл, тарнийн ид шидийг өвлөн авснаар өөрийнх нь сэтгэлд нийцээгүй элдэв зүйлээс эхлээд нутаг нугын энгийн ардын амийг авч, айл гэрийн болон өөрийнхөө амьдралын амгалан тайван байдал, гал голомтыг самран, сайхан сэтгэлт хүмүүсийг өрөөл татуу болгон өвчин зовлонд унагаж, өчүүхэн балчрыг ч үл тоон егүүтгэхийг оролдон өөрийн эхнэр, охин хоёроо амиа хорлож, нүдээ сохлох аргагүй байдалд хүргэн сэтгэлийн гашуун зовлонд унагааж, эцэстээ “*хадаг явж бурханд, хараал явж толгойд*” гэгчийн адилаар сэтгэлийн зовлон зүдүүр амссан ард олны хүчинд автан гэрээ шатаалган “*Хаврын тэнгэр намайг авч явах нь*” хэмээн дэмийрч, эхэр татан амь тавьж байгаа үйл явдал бол зохиолын гол өгүүлэмж юм. // Уран зохиол ба ёс зүй. 2016. Дугаар 115. Зохиолч Д. Цэнджав “Хөх жавар тууждаа ёс зүйн үзэл санаа, ёс суртахууны доод илрэл болон дээд чанарыг шингээн урлахдаа хүний дотоод сэтгэлтэй нарийн нягт уялдуулан урласан нь уг туужийг сэтгэл зүйн тууж хэмээн үзэх бүрэн үндэстэй болгож байна.

“Хөх жавар” туужийг сэтгэл зүйн тууж гэдгийг батлах бас нэгэн баримт бол зохиолч зохиолын эхэнд “Психоанализмын эцэг” гэдгээрээ нэртэй сэтгэл судлаач Зигмунд Фрейдin хэлсэн “*Ай бурхан минь, би чинь ямар л хүмүүстэй хамт амьдарч байж вэ дээ...*” // “Тэнгэрт хальсан тоос” шилмэл туужууд. 2014. Дугаар 12 гэсэн уялга үгээр зохиолыг эхлүүлсэн нь энэхүү туужийг сэтгэлзүйн тууж болохыг баталж байна. Үүнийг зохиолтой холбон авч үзвэл Д. Цэнджав хараалч хүний дүрийг нүдэнд харагдаж, сэтгэлд хар буутал тууждаа дүрсэлсэн явдал юм. Үүнийг Хөх Цавьт болон түүний хүү Харлаг Доной нарын дүрээс харж болно. Өөрөөр хэлбэл туужид хүний сэтгэлийг татах нэгэн ер бишийн увдъс буй. Энэ нь зохиолыг уншиж эхэлсэн хүн заавал дуусгахаас нааш санаа үл амарах, сэтгэлийн догдлол, харамсал, уйтгар гуниг, баяр бахдал, омогшил, айдас хүйдэс гээд бүх мэдрэмжийг нэгэн зэрэг мэдрүүлж чаддаг туурвилзүйн онцлогтой нь холбоотой юм. Тиймээс уг туужийг уншиж дуусгаж байж л тэрхүү хар дом, хараалын хүч уншигчид үл нөлөөлөх юм шиг санагддаг ба дутуу орхивол Харлаг Донойн хүйтэн харц араас мөшгөх мэт эвгүй сэтгэгдэлд эзэмдүүлэх нь гайхалтай

сэтгэлийн мэдрэмж юм. Энэ мэт хүний сэтгэлийн олон өнгө аясыг нэгэн зэрэг төрүүлж байгаа нь чаддаг ун туужийг сайхан болгож байгаа зүйл төдийгүй түүний үнэмшилт чанар юм. Тухайлбал “...Угийн дуугүй хүлцэнгүй, газар ширтсэн доройхон Доной...” Хөх Цавьт хэмээх аавтайгаа уулзаад удам дамжиж ирсэн хараалын хар домьг уламжлан авахдаа эхэндээ айн ширвээдэж, татгалзан, эргэлзэх аж. Гэтэл аав нь үүгээр хүссэн бүхнээ гүйцээж болно гээд “...Би энэ муу залуу хүүхнийг тарни номын хүчээр л өөртөө татсан юм шүү дээ. Хүсэл тачаалаа ч гүйцээж болно. Миний ажгаа “Монди Тарав” гэгч ер нь айхтар хэлэмгий, доломгой сэргэлэн, ганц гэм нь эм сүвтэй юмны өвчин туссан шиг сахилгагүй хүн байсан юм. Саваагүй зан нь хөдлөөд айлын эм ямааны чихэнд наад тарианаа уншихсан юм гэнэ лээ. Тэгсэн мань хүнийг мориндоо мордоход нөгөө улаан ямаа чинь майлаад хойноос нь гүйгээд салахгүй байсан гэж байгаа...” гэх мэтээр ярина. Үүнийг сонсож байсан нунж дорой Донойг: “...дэмий л санааширан нүдээ унагаахаас өөр юмгүй, “үзвэл мөн ч гоё байх даа” гэж дотроо хүсч тачаадаж явдаг жаахан Бадамаагийн жоготой хар нүд тормолзон, цог жавхлан нүүрнийхээ арьсны цаанаас нэвт туяарч гэрэлтсэн зүс царай бүүр холоос тодроод ирэх шиг болоход “Юу хүссэнээ хийж болно гэнээ” гэж дотроо үглэн, саяхан л үүлгэртээ учраа олохгүй мэгдэж байсан Доной алгуур аажмаар ер бусын зоригоор хөвчлөгдөв” // Тэнгэрт хальсан тоос” шилмэл туужууд. 2014. Дугаар 24 гэж өөрчлөгдөж байгаагаар дүрсэлсэн нь нэн сонирхолтой өгүүлэмж юм. Угийн доогуур харцтай, дорой дуутай Донойн хараалыг өвлөж авах мөчийг нь нутгийн бүсгүй Бадамааг харж, далдуур хүсэн тачаадаж явдагтай нь холбожээ. Энэ нь Фрейдизмын онолоор бол Донойн дотор хуримтлагдсан бэлгийн дур тачаал буюу либидотой холбож асуудлыг шийдвэрлэсэн хэрэг юм. Доной муу ч гэсэн эр хүн л болсон хойно “нэг үзчих юмсан” гэж дотроо бодож явдаг хүүхэн байж л таарна. Тэрхүү эр хүний нууцхан хүсэлтэй нь ийн холбон дүрсэлсэн нь нунж дорой Донойг өөрчлөгдөхөд хүргэж байгаа бөгөөд мөнөөхөн З.Фрейдын онолын хүний далд ухамсрын үйл ажиллагаа нь хүний бүхий л үйл ажиллагаанд нөлөөлж байдаг гэдэгтэй уялдуулж үзвэл энэ нь үнэмшилтэй гэхээсээ илүү зөв шийдэл юм. Мөн энэ жишээ нь зохиолчийн мэдлэг боловсрол, ур чадвар, авьяас, мэдрэмжийн хэр хэмжээг бэлхнээ илтгэх ажээ.

Үүнээс гадна хөдөө нутгийн ахуйг тод сонин өнгө дэвсгэр дээр хүмүүсийн үзэл бодол, ааш араншин, үг үйлдлийг хүн ба ахуйдаа уусан зохицсон яруу хэллэгээр маш тод ялгаруулан дүрсэлсэн зохиолын нэг нь “Тэнгэрт хальсан тоос”/2014/ тууж юм. Туужид хүний сэтгэл зүйн үй түмэн хувирал бүхий өгөгдөхүүний бодит мөн чанартай хослуулан урласнаар нь сэтгэл зүйн туужид хамруулан авч үзлээ. Туужид дүрийн бодол ухаарал, дүрийн харьцаа тэдний сэтгэлийн хэсэгхэн уур бухимдлаас болж хийж буй мунхаграл зэргээр хүний сэтгэлд хүрч тусах хэсгээр баталж болох юм. Тухайлбал: Зохиолд дүрийн дотоод ухаарлыг харуулахдаа Базарын бодол эргэцүүлээр гаргажээ. Тухайлбал: “Авгай хүүхдийн хэлдэг ортой ч юм уу? хориод жил нэг уяанд нийлцгээж, энэ Дулмаа, Чимгээ хоёр чинь нэг майхны тогоо шанага хангинуулаад хүзүүнээсээ холбоотой юм шиг л яваагүй гэж үү? Дамдинг хүмүүс янз янзаар л ярьдаг. Тэр ч яахав, өөгүй хүн хаа байлаа. Надад ч зөндөөн муу юм байж л байгаа. Гэхдээ бид хоёрын хооронд ташуур шургах зайгүй явсан юмсан. “Уяа уяандаа наадья” гэдэг үг тунчиг ёозгүй дуулдаж байна гээч. Тэр зартай хурдны торгон магнайд миний

уяаны хэдийн тоос лав муу болохгүй дээ. Их бага гэлгүй морьд чинь тоос тоосондоо хийморь ордогсон. Хэд хоног цуг майханлаж, нэг сунгуу тараа хийж хөлс аваад энэ тэрийг шинжээд хоёр тийшээ салж болно доо. Цуг бүдэрч, дуулж, уйлж явсан эр улсууд шүү дээ. Дамдин бид хоёрын хөгийг алийг хэлж барахав. ...Түүнээс хойш юу ч болоогүй юм шиг л орж гарч инээлдэж шуугилдаж яваа биз дээ. Чимгээ бид хоёрыг хардана гэж баймааргүй юм. // “Тэнгэрт хальсан тоос шилмэл туужууд. 2014. Дугаар 155-156 гэх мэтчилэн бодсоны дараа өөрийн хүүг манай энэ хар архи ууна, агсан тавина. Бас ядаж хэвтэж авгай хүүхэн эргүүлнэ гэж бодсоны дараа өөрийнх нь эцэг түүний хар багад нь хэрхэн өсгөж хүмүүжүүлж байсан болон эцэг нь ямар хүн байсныг ч дурсана. Ингэхдээ Муу аав минь хэвтэрт орчхоод байхдаа Дамдинг зориуд дуудаж авчруулаад: Хүү минь тоосоо харж яв даа гээд аймгийн наадамд нэг түрүүлж, гурав айрагдсан зартай хээр халан азаргаа өгөхөд би голоо горойтол гомдсон... Хар ухаан гэдэг чинь өөр юм билээ дээ. чухамдаа тэр хурдан азаргаар надад насны нөхөр олж өгч байгаа нь тэр шүү дээ. // “Тэнгэрт хальсан тоос” шилмэл туужууд. 2014. Дугаар 157-158 гэж нэгэн шөнө бодсоор тун удалгүй гэрийн хатавчаар гэрэл гялбан өглөө боллоо. Ийнхүү Базар нэгэн шөнө бодож эргэцүүлж, түүний дотоод ухаарлаар дамжуулан түүний сэтгэлзүйг нэвт тусгаж өгсөн нь энэхүү туужийг сэтгэлзүйн тууж болохыг харуулж байна. Энэ мэт До. Цэнджавын сэтгэлзүйн туужууд нь утга агуулгаар улам баяжигдан хөгжиснийг “Гүн тайгын манан” /1996/ туужаас нь харж болно. Зохиолч уг туужаа “Гүн тайгын манан”, “Тэнгэр уулын манан” гэж хоёр нэртэйгээр хэвлүүлэн гаргажээ.

Манан гэдэг нь нэгд усны уур дүүрсэн тунгалаг бус агаар, хоёрт тоос, утаа, гуравт шилжсэн үймээн, бужигнаан // Монгол хэлний товч тайлбар толь. 1966. Дугаар 329 гэсэн утгатай бөгөөд энэхүү манан хүний сэтгэлд хэрхэн илэрдгийг зохиолд “Урагшлах аргагүй болжээ. Чиг баримжаа алга. Гэвч горьдлого тасрахгүй урагшаа яваад л байвал хөглөгөр их хөвчийн захад гарах юм шиг санажээ, тэр. Огт танихгүй мэдэхгүй газрын зах руугаа биш харин улам гүн тийшээ ярган яваад байх шиг санагдахад Гарьдад айдас хүйдэс өөрийн эрхгүй төрж эхлэв.” гэснээс харж болно [<https://www.book.mn/>]. Зохиолч энэхүү туужийг нэрлэхдээ “Гүн тайгын манан”, “Тэнгэр уулын манан” гэж нэрлээд үүнд гарах манан нь хоёр утгаар хэрэглэгдсэн болох магадлалтай. Үүнд: 1. Хорьдол Сарьдагийн хөлгүй ой тайгад гэртээ харьж чадалгүй буцах замаа мэдэхгүй манан дунд төөрсөн хүн мэт байх нэг дүрслэл. 2. Тунгалаг бус агаар шиг болсон дүрийн дотоод сэтгэлзүй манан мэт учир битүүлэг хувирч, зан авир нь төөрөлдөх энэ хоёр утгаар зохиолд гарах болно.

Анхны цаснаар буюу өвөл цагийн эхэнд Гарьд төөрч ганцаар төөрсөн түүнд тэр ой тайга манантсан мэт байх бөгөөд харих замаа ололгүй байсаар бүтэн жил тэрхүү ой тайгад амьдарна. Энэ жилийн хугацаанд түүний оюун бодол ч тэр манантсаныг зохиолд тусгахдаа Цэнгэл, Ургамал гэх хоёр бүсгүйтэй учирч хамт амьдрахдаа эхэнд Цэнгэлтэй биеийн жаргалыг эдлэх авч Ургамалд хайртай болж тэр хоёр хүүтэй болдог. Цэнгэл гэх эмэгтэй өөрийн эрийг булаалгасан мэт сэтгэгдэл төрж Гарьдтай учирснаас хойш түүний ч мөн оюун ухаан, дотоод сэтгэл зүй нь манан мэт бүрхэнэ. Тэр өмнө нь хэзээ ч эр хүнийг тэгж шуналтайгаар хүсч байгаагүй боловч Гарьдтай учирснаас хойш хайрлаж явсан эр хүнээ булаалгахдаа оюун санаа нь галзуурсан мэт болж, тэр ч байтугай нэг эрийг хоёул эдэлж байя // Гүн тайгын манан. 2017. Дугаар 78 гэж хэлж байгаагаас

харахад туужийн гарчигтай холбогдож тэдний сэтгэл зүй манан мэт тунгалаг бус болон хувирсныг харж болох юм.

Түүхэн тууж Түүхэн тууж нь түүхийн баримтад түшиглэсэн туульсын зохиолын нэг хэлбэр юм. Туульс туужид уран сайхны дүрслэл, сэтгэлгээний оролцоо илүү бол түүхэн туужид түүхэн бие хүн, түүхийн баримт гол байртай. Туульс туужид цаг хугацааны хязгаарлал багатай, харьцангуй чөлөөт өрнөлттэй байхад түүхэн туужийн хэрэг явдал түүхэн хэрэг явдал, түүхэн цаг хугацаагаар хязгаарлагддаг улс үндэстний оршин тогтнож ирсэн түүхийн баримтад тулгуурлан уран сэтгэмж, уран дүр, дүрслэлээр баяжуулан бичдэг онцлогтой. С. Дулам “Түүхэн ба баримтат зохиолыг ургуулан бодохуйд” хэмээх өгүүлэлдээ “Түүхийг эдүгээчлэх юмуу санааны зоргоор засварлаж, аль алинд нь харш нийгэм түүхийн хөгжлийн гол чиг хандлагын үүднээс нэгтгэн дүгнэдэг түүхэн зүйн зарчмыг баримтлах нь түүхэн болоод баримтат зохиолыг туурвих гол чиг баримжаа мөн”// XX зууны монголын уран зохиол судлалын дээж бичиг. 2007. Дугаар 195 гэсэн байдаг. Бид энэ мэт онолын үндэслэлд тулгуурлан Хиагтын гурван улсын гэрээний талаар өгүүлсэн “Тал сар” /2014/ туужийг О. Батсайханы “Монголын сүүлийн хаан Богд Жавзандамба хутагт” /2008/ хэмээх бүтээлтэй харьцуулан авч үзлээ.

Хүснэгт-1

О. Батсайхан «Монголын сүүлийн хаан Богд Жавзандамба Хутагт»	«Тал сар» тууж	Дүгнэлт
1915 оны Хиагтын гурван улсын гэрээ нь колоничлол ид ноёрхож байсан цаг үед байгуулагдсан бөгөөд энэ үед их гүрнүүд бага буурай оронд өөрийн хүсэл эрмэлзлийг тулган хүлээлгэдэг эрх тэгш бус зарчим үйлчилж байв. Хиагтын гэрээнээс өмнө 1913 онд Орос, Хятад хоёр Монголын асуудлаар тусгай гэрээ байгуулаад байв. Тэрхүү гэрээгээр Монголын Хятадын эзэн эрхийн дор орших автономит улс байхаар тогтжээ. Гурван улсын хэлэлцээрээр хоёр тал үүнийгээ Монголын талд тулган хүлээлгэхийг гол зорилгоо болгосон билээ. Гэрээг хэлэлцэх явцад гурван тал өөр өөрсдийн байр суурийг хатуу баримталж, санал ихээхэн зөрж байв. Тиймээс Хиагтын хэлэлцээр 1914.08.26-аас 1915.05.25 хүртэл бүтэн есөн сар сунжран үргэлжилжээ // Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. 2013. Дугаар 404	“Засгийн газрын дэд сайд зэрэг төрийн том албанд ажиллаж байсан өвөр монголын ноёдыг Бээжинд буцаах болов, ар өвөр салж хагацав гэлцэн Чагдаржавын чихийг халууцуулж, төмөр мэт хатуу үг хэн нэгэн гараараа түүний зүрхийг нь базах шиг санагдана. Хүний нутагт бүхэл бүтэн есөн сарын турш тусгаар Монголоо гэсэн нэгэн чин сэтгэлийг хатуу барьж зүтгэсэн Чагдаржавын толгой дээр хэлэхгүй муу үгийн угаадсыг ингэж цацжээ ” // Тэнгэрт хальсан тоос” шилмэл туужуу. 2024. Дугаар 590–591	Эндээс харахад Хиагтын хэлэлцээр 9 сар үргэлжилсэнг До. Цэнджав тууждаа мөн есөн сар хэмээн түүхэн баримтыг гуйвуулалгүй дүрсэлсэн байна.

О. Батсайхан, “Монголын сүүлийн хаан Богд Жавзандамба Хутагт”	“Тал сар” тууж	Дүгнэлт
Тухайн үед Хиагтын гэрээнд оролцсон Монгол улсын засгийн газар түүний бүрэн эрхт төлөөлөгчдийн тавьсан гол зорилго нь: 1. 1911 онд тунхагласан улсынхаа тусгаар тогтнолоо баталгаажуулах. 2. Монгол Улсын засгийн газрыг дэмжиж нэгдэхээ илэрхийлсэн Өвөр Монгол болон бусад Монгол үндэстэнээ өөрсөдөө хамааруулах зорилго байсан. Энэ нь нэг ёсондоо тусгаар тогтнолоо баталгаажуулах, Монгол улс хоорондоо нэгдэн нийлэхээ илэрхийлсэн мөн бусад Монголчуудаа өөртөө нэгтгэн авахыг зорьж байв. // Монголын сүүлийн хаан Богд Жавзандамба Хутагт. 2008. Дугаар 290-292	Энэхүү түүхэн баримтыг зохиолд тусгахдаа: “Цэвээн Жамсранов хөөцөлдөж хотоос зайдуухан нэгэн ой модтой нууц газар олоод Чагдаржавыг Хиагт дахь оросын хилийн төлөөлөгч хурандаа Хитров, бас нэгэн дээд тушаалын генерал, төлөөлөгчийн тэргүүн Миллер нартай уулзуулжээ. Чагдаржав: Яавал монголын тусгаар тогтнолыг авч үлдэх вэ? яавал наашаа нүдээ ширгэтэл, ясаа цайтал ширтээстэй цус махны холбоотон өвөрлөгчдөө нэгтгэх вэ? гадаад бодлогын асар туршлагатай танаас энэ ал дээр гүн туслалцаа авахыг үнэхээр хүсэж байна...” // “Тэнгэрт хальсан тоос” шилмэл туужууд. 2014. Дугаар 559-560	Тухайн үеийн болсон бодит үйл явдлыг туужид мөн ижил дүрсэлсэн байна. Ингэхдээ тусгаар тогтнолоо баталгаажуулах, Монгол үндэстэнээ өөрсөдөө хамааруулах зорилго зэргийг гуйвуулалгүй дүрсэлсэн байна.

Автономит Монголын хил хязгаарыг тогтоохдоо "Хүрээний сайд, Улиастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд агсан газрууд бөгөөд Дундад улстай нийлсэн хил болбоос зүүн зүгт Хөлөнбуйр, өмнө зүгт Дотоод Монгол, баруун өмнө зүгт Шинэ Газар (Шинжааныг хэлж байна), баруун зүгт Илийн хязгаартай зааг нийлсэн Халхын дөрвөн аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр буй" гэжээ. Үүнийг Ар Монголд автономит төдий эрх олгоод түүнд нэгдээд байсан Хөлөнбуйрын Баргыг салгаж "тусгай район" болгох, бусдыг нь ДИУ-ын ноёрхолд үлдээх болсон учраас нэгэнт тусгаар тогтноод 4 жил шахам болсон Монголын хувьд харгис үүрэг гүйцэтгэсэн гэж түүхч Л. Жамсран бичжээ. // “Тэнгэрт хальсан тоос” шилмэл туужууд. 2014. Дугаар 559-560 Ийнхүү тэртээ 1915 онд болсон Хиагтын гурван улсын гэрээ болох Орос, Монгол, Хятад гурван улсын хооронд болсон түүхэн үйл явдлыг зохиолч До. Цэнджав “Тал сар” тууждаа дүрслэхдээ түүхийн баримтад түшиглэн, тухайн үеийн нийгэм-түүхийн гол чиг хандлагыг илэрхийлж, түүхэн онцгой чухал үйл явдлыг гол байранд нь гарган дүрсэлсэн учраас түүхэн тууж гэж үзэх боломжтой байна.

“Цахарын хар шуурга” /2007/ туужид Монгол Улсаа гэж өвчүү элгээ дэлгэж, өрөвлөг үсээ үтрээн зовсон бүгдийн маань бие цуваа цуваагаараа чилээрхэж үхдэгийн учир юу вэ? энэ асуултыг тэртээ зуунд Цахар Барга, зарим түүхэнд Харчин гэгддэг домогт жанжин, гүн Бавуужав өөрөөсөө асуужээ. “Өвөрлөгч дөчин есөн хошууг Манж, Хятадын дарлалаас бүр мөсөн чөлөөлж, эцэг өвгөдийн үеэс тогтоосон өмнөд зүүн хявзаарыг Цагаан хэрэмнээс наахнуур ханын шийрээр дугуйлах мэт болгох их үйлсийг...” эхлэлээс нь аваад эцсийн горьдлого тасартал

нь амь хайргүй явж ясаа дэрлэсэн гүн Бавуужав гэж хэн байв. “...Гүнтэний мах шөл тэнцүү чилгэр тэгш бие, догшин хөх царай, эмтэршгүй цахиур чулуу мэт хатуу зориг, нэг яс чигээрээ зан, хааяа хүүхэд шиг гэнэн, буцалсан онгиргон ааш...” бидний үед нэг их цуурайлан хүрч ирсэнгүй ээ. Гэтэл зохиолч Д. Цэнджав энэ цаг үеийн гол асуултыг одоогийн биднээс асуух гэж “Цахарын хар шуурга” хэмээх туужид сүнс сүлдээ шингээн бичжээ. Зохиолынхоо дүр гүн Бавуужавын гомдолт бодролоор ийнхүү өдөж асууж урласан байна.

Зохиолчийн мөшгисөн түүх, бичсэн “дуульд” гүн Бавуужавыг хар хятадуудын эсрэг сэлэмнийхээ ир, жадныхаа үзүүр болгон манай халхчууд, хүрээний ноёд ашиглагчаад, бусад цагт бар ирвэсийн хөнжилд таатай дугжруулахгүй эх орноо худалдахад нь саад болоод болохгүй болохоор нь өнөө л хятадуудтайгаа хавсайдан хороочихож байгаа юм.

Монголчууд хүнээ, баатар эрээ, хурдан хүлгээ, ухаантан мэргэдээ ганцаардуулж алахдаа гарамгайг зохиолч дахиад л сануулж бичжээ. Бавуужав, түүн шиг ямар олон эх оронч ганцаардлаар нас бараа вэ? энэ бол зохиолын нууц санаа, амин сүнс бол монгол хүн, монгол хүндээ хайртай байгаач ээ” гэсэн эртний эрсийн цусаар бичсэн уриа гэж ойлгогдоход хүргэж байна. Энэ туужийн цөлх сайхан эр “Булуу Түвдэн” шиг яс цус нь монгол эрчүүл Монголд ховордсоныг зохиолч гүн Бавуужавын дайчин хурц, өрөвдөм дүрийн эргэцүүлэл бухимдлаар монгол төрийн доройтсоны учрыг тайлахыг хичээжээ. Түүх ахуй, зан чанарын өвөрмөц хөргүүдийг торгоны хээ мэт ялгаруулан зураад зогсохгүй, өнөө цагийнханд өчнөөн олон бодол, ухаарал өгөх амьд зохиол болсон байна. Туужид *“Энэ өчүүхэн муу Монголын газар нутгийг сийчээд байх нь зүй. Осолдохгүй газар дээр хөл нь гишгээж, мал нь явж байвал газар байнаа гэж боддог улс. Түүнээс газар гэдэг бурхныг мэдэх ч үгүй, түүнээс юу авдгийг төсөөлөх ч үгүй. Орос Монголд наанаа тусалсан дүр үзүүлээд цаагуураа бүх юмаа хийж байна шүү дээ... эд ч бас Орост тийм сайн биш. Арга ягдаж байгаа юм... Дундад иргэн бүр нэгжгээд малгай, өмд хоёроо тайлаад шидчихэд л... тэр чигээрээ битүү даруулж, бүтэж үхнэ шүү дээ. тэр уул манайх, эртнээс нутаглаж байсан гэж согтуу малчин ташуураараа нэг заахчмаан болдог гэнэ лээ... гээд үхрийн нүд шиг хундагаар дорнын газрын хүчтэй моатуу архи шимж...”* // Хөх жавар. 2009. Дугаар 245 суусан арван есдүгээр зууны Хятадын төрийн бодлоготны үг харамсалтай нь түүхэн үнэн юм. Энэ үнэнийг Цэнджав хэлэхээсээ айж бэргэсэнгүй. Ясны уран бүтээлч, элгэн садан үр нь л ард түмнээ хэзээ яллаж, хэзээ өмгөөлөхөө мэддэг тэр л хуулиар Цэнджав ард түмэндээ хэлэх үгтэй зохиолч гэдгээ уг туужаараа харуулж чадсан байна.

“Өнцөгдсөн сэнтий” тууж нь эртний хүчирхэг хатдын амьдрал хийгээд тэдгээрийн хатан ухаан болон хаан ширээний төлөөх тэмцэл, алтан ургийн дундах хагарал тэмцэл болон Их Монгол улсын төр барьсан монгол эмэгтэйчүүдийн дотроос анх төр барьсан Өгэдэй хааны Дөргөнэ хатны талаар гардаг. Энэхүү тууж нь нэг талаар туурь тууж гэж хэлж болох ч нөгөө талаар түүхэн тууж гэдэг нь илт байна. Түүхийг сөхвөөс: “1241 онд Өгэдэй хаан нас барснаас хойш 1246 он хүртэл түүний эхнэр Дөргөнэ хатан хаан ширээг барьж их хуралдайн шийдвэрээр Гүюг төрийн эрхийг залгамжлан авчээ. Энэ зуур Сорхагтани Гүюгийн дүү Боржигины толгойлогч Алтан ургийн хамгийн ахмад нь болох Бат хаантай нэгдэв. 1248 онд Гүюг Бат хааны газрыг эзлэхээр дайтаж яваад нууцлаг шалтгаанаар өөд болжээ. Үүнд Сорхагтани хамаатай байж болох

таамаг эдүгэ судлаачдын дунд байдаг. Гүюг нас барсны дараа Сорхагтани өөрийн том хүү Мөнхийг Бат хаан руу явуулж, Бат хаан түүнийг олон тулаанд хамт тулалдсан гээд цэргийн ахлагч болгон томилжээ. // Архелогийн олдвороор олдсон түүхийн дурсгалууд. 2002. Дугаар 223-226 Зохиолч До. Цэнджав “Өнцөгдсөн сэнтий тууждаа энэ үйл явдлыг тусгахдаа ийн өгүүлжээ. “Өгөдэй их хааныг тэнгэрт хальснаас хойш таван жил өнгөрч, хатан Дөрөгэнийн хатуу чанга гарт монгол захирагдсаар байлаа. Гүег хэзээ хаан ширээгээ надад өгөх бол?, харасаар байна. Гэвч Дөрөгэний нас ахиж, тал талын дайсагнал хавчлагад өөрийн эрхгүй автаж хүү Гүюгдээ төрийн эрхийг хагас дутуу өгч эхлэв. Хаан тамгыг атгаад жил гаруйхан болсон Гүег юун түрүү Батын эзэмшил “Алтан ордыг” номхоруулах Батыг дарах гэж явах замдаа гэнэт тэнгэрт хальжээ.” // Хатан цадиг. 2014. Дугаар 45 Ийнхүү дээрх түүхэн үйл явдлыг зохиолч До. Цэнджав “Өнцөгдсөн сэнтий” тууждаа мөн ижил Өгөдэй хааныг нас бармагц түүний зургаа дахь хатан Дөрөгэнэ хаан ширээг барьж өөрийн хүү Гүегдээ төрийн эрхийг өгсөн хэдий ч бүрэн өгөөгүй өөрөө удирдсан үйл явдлыг туужид өгүүлсэн байна.

Эсээ тууж ЭСЭЭ (фр. *essai*, англ. *essay*) Францын хэлний туршлага, оролдлого, найруулал, зохион бичлэг, бодрол зэрэг олон утгат нэр томъёо. // Уран зохиолын онолын ойлголт нэр томъёоны тайлбар толь. 2002. Дугаар 540 Эсээ нь хүүрнэл /туульсын болон сэтгүүл зүй, судалгаа шинжилгээний/ зохиолын нэг зүйл юм. Эсээ уран зохиолд ямар нэг шалтгаан хийгээд асуудлын талаар хувь уран бүтээлчийн бодол эргэцүүлэмж, таамаглалыг шингээсэн юмс үзэгдлийн мөн чанар, шалтгаан, холбоо хамаарлыг заавал бүрэн буюу гүйцэт илэрхийлсэн байх албагүй бэсрэг хэмжээтэй, чөлөөт уран сэтгэмж, чөлөөт зохиомжтой үргэлжилсэн үгийн зохиолын бие даасан шинэ төрөл-зүйл болж хөгжижээ.

Энэ өвөрмөц төрөл-зүйл зохиолчийн бодгаль шинж давамгайлсан бүтээлүүдэд анх боловсорсон гэж үздэг. Тухайлбал Лукианы эртний бүтээлүүд, М. Монтений бичвэрүүдийн дараа уран зохиолд бие даасан жанр болжээ. Эсээ хөгжилд Ж. Дони, Г. Фильдинг, Д. Дидро, Ф.М. Вольтер, Г. Лессинг, И. Гердер, Г. Гейне, Г.Д. Гора, Б.К. Честертон, Г. Адамс зэрэг томоохон уран бүтээлчид их хувь нэмэр оруулжээ. XX зууны үргэлжилсэн үгийн зохиолч, яруу найрагч, гүн ухаантнууд байгаль болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны ололт, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, уншигчдын янз бүрийн хүрээг нягтруулах зорилгоос эссе төрөл эрчимтэй хөгжсөн байна. Манайд эсээ хэмээх энэхүү төрөл бие даан хөгжиж төлөвшиж байгаа бөгөөд До. Цэнджавын туужид ч уусан шингэсэн нь ажиглагддаг. Ингээд зохиолчийн зарим эссе хэмээх төрөлд багтах зарим туужаас авч үзье. “Маргааш л дайн эхэлчих юм шиг 1080 хоног минь” туужид оюутан болсон жил нь Цэнээ хүүд цэргийг зарлан ирж, ямар нэгэн арга замаар хөөцөлдөн явахгүй байх арга олохыг хичээсэн боловч бололгүй цэрэгт явахаар болдог. Зохиолын гол баатар Цэнээ бол зохиолч өөрөө юм. Тухайн үед цэрэгт гурван жилээр татагддаг байсан бөгөөд энэ гурван жил буюу Цэрэгт байх 1080 хоногт шинэхэн цэргийн зовлон болоод хүнд дэглэлтийг мэдэрч байсан үе болон бусадаасаа бичиг цаасны ажилд гарамгай байж карантин дууссаны дараа бага түрүүч цол авч бага даргын сургууль салааны тасгийн дарга болж хоёр дахь жилээс шинэ цэргийн карантины жагсаалын даргаар очоод удаагүй байтал ахлах түрүүч цол хүртсэн гавьяатай зэрэг өөрийн амьдралынхаа хоромхон хэсгийн үйл явдлыг эссе тууж болгон уншигчдын хүртээл болгосон байна. Зохиолч энэ мэт

бодит үйл явдлыг уран сайхнаар баяжуулахдаа эссэнд тавигдах ямар нэг шалтгаан хийгээд асуудлын талаар хувь уран бүтээлчийн бодол эргэцүүлэмж, таамаглалыг шингээсэн, юмс үзэгдлийн мөн чанар, шалтгаан, холбоо хамаарлыг илтгэсэн, чөлөөт уран сэтгэмжтэй, бичлэгийн хэв маяг нь товч, уран, дүрслэг шинжтэйгээс гадна ярианы аялга зэргийг багтаасан гүн утга агуулгатай өвөрмөц зохиол болгон урлажээ. Жишээ нь: *“Хоёр даргаасаа үнэлгээ авлаа. Хэрэндээ маадайгаад явчихав. Домогт цэргийн ангийн алдарт штабт хугацаат албаны ердөө хоёрхон цэрэг ажиллана. Нэг нь Жигмэддорж, нөгөөх нь би. Намайг ангийн жижүүр дээд тушаалын офицер хүртэл зориглож босгохгүй, дураараа хүн болж билээ. Штабт шөнө орой болтол сууж юм хийсэн гэх тайлбартай. Оройн тоонд жагсахгүй. Ер нь “сэтэрлэгдсэн цэрэг” гэж байдаг бол, тийм маягаар байсаар байгаал халагдсан даа. Бичгийн машинаар овоо бичиж сурав. Үдэшлэг уулзалт хөтөлж, яриа таниулга хийж, ханын сонин гаргаж, элдэв хүмүүсийн шагналын тодорхойлолт хийж ер зай завсаргүй ажиллуулж, бичиг цаасны дороос толгой өндийлгөдөггүй байсан нь надад ёстой “их сургууль” төгссөний дайтай, одоо элдэв юм эрээчдэгийн эх болсон билээ // Маргааш л дайн эхэлчих юм шиг 1080 хоног минь тууж. 2009. Дугаар 613 гэснээс харагдаж байна.*

Туужийн төгсгөлд зохиогчийн буюу би баатрын бодол эргэцүүллээр төгсөж байгаа нь энэхүү туужийн гол үйл явдал болох цэргийн алба хашин 1080 хоногт ямар байсныг тухайн хүнд ямар сэтгэгдэл төрж байсныг харж болно. Энэ нь өнөөх эссе зохиол байх хувь хүн уран бүтээлчийн бодол эргэцүүлэмж, нөгөө талаас гүн утга агуулгыг “Маргааш л дайн эхэлчих юм шиг 1080 хоног минь ард үлдлээ. Баяртай. Дахиад л би зэвсэг барьж, дахиад л цэрэгт хэзээ ч дайчлагдахгүй ... Үздэг юмаа үзлээ. Одоо больё. Ёох ... хэд хоног...” гээд «хөл хорио» хэмээх шинэ цэргийн 45 хоногийн хугацаатай чангаланд орсон. Энэ нь хорих газраас ч хэцүү даваа. Ямар ч бүдүүн хүзүүтийн шил сэтгэрнэ дээ. Хааяа гадны эргэлт ирэхэд эхлээд дарга нарын гараар орж, шавхруу нь бидэнд ирэхтэй үгүйтэй. Шинэ цэргүүд хорь тоолохын зуур багтаж хувцаслаад жагсаалын шугам дээр хар эрчээрээ очиж, биеэгнэн жигдрэх ёстой. Уйдсан дарга нарын зугааг гарган дэглүүлнэ. Намрын сүүлчээр хүйтэн бороонд нүцгэн удаан зогсоно. Тэр үед шүд эрүү хоёр өөрийн эрхгүй хоорондоо зодолдож эхэлнэ. Бага дарга нарт толгой тархигүй нэвширтлээ зодуулаад дууслаа гэсэн өнөөх бага дарга нар маргааш нь ирж гар дээр өчнөөн суниалгасан. Хоол идэх гэсэн боловч гар дээшээ явдаггүй. Нэг хэсэг далавчгүй шувуу шиг юм явав. Ай хөөрхий, халагдах энэхүү цаг хугацааг хичнээн бэтгэрч хүлээвээ. Зуун жилийн дайтай 1080 хоног гэдэг ёстой матар шиг мөлхөж заан шиг алхаж байсан даа...” гэх сэтгэгдэл мэдрэмжтэй байсан үеийг нүдэнд харагдтал тод томруунаар харуулсан нь эцсийн дүндээ өгүүлэгдэн буй үйл явдлын сургамж санааг шүүн тунгааж, уншигчийн өөрийн үзэл ойлголт дүгнэлт болгох нарийн үйл явцыг харуулсан байна. Энэ мэт эссе зохиолын төрөлд хамрагдах тууж бол **“Буурал ижийнхээ хөлийг хучиж чадлуу”** хэмээх зохиол юм. Энэ туужид зохиолч өөрийн амьдралын нэгээхэн үйл явдлыг өгүүлэн намтарчилсан зохиомжтой өгүүлсэн байна. Ингэхдээ эмэгтэй хүний тухай, түүний дотоод ертөнц, эрхэлдэг үйл хэргийн тухай хэлэхдээ өөрийн эх болох Долгор нь ямар хүн байсан талаар болоод хэрхэн ардын ухаанаар үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлсэн гээд зохиолчийн харуусал, өөрийнх нь хэлснээр түүний тэмдэглэлийн дэвтэрт үлдсэн халаглал буюу нэхэл нийтлэл олон хүнийг юм бодуулж, ухаарлаар хөглөх гайхамшигтай бүтээл гэдэгтэй хэн ч маргахгүй

байх. Үүнийг тодруулбал: “Ус нутгийнхан ижийг минь Догоо гэж авгайна... ээж минь мөн ч гүйн хар ухаантайсан. Хүний үгэнд ухаан гэрэлтдэг хойно доо. “Хоноцын хөнжил дулаан бол айл гэрийн нэр дулаан”, “Хүнийг харж зүсээ, айлыг харж гэрээ”, “Хүн болно гэдэг чинь бие биеэ дэрлэсэн чулуу л гэсэн үг. Нэг нь хөдөлбөл бусад нь дагаад холхидог”, “Хүн маргаашийнхаа өмнө дальдарахааргүй амьдаръя гэвэл сэтгэлдээ харгүй явах шиг сайхан явах юм үгүй. Эгвэл чи тааралдсан болгонтой инээн уулзаж, инээж сална... Сарны туяа адил цээжинд сүлэгдэн үлдсэн ижийнхээ эл үгүүдийг номын хуудаснаас өнөө хүртэл олоогүй, ээж минь бодож, түгжрэлгүй урсгасан өдий төдий үгийн зөхөн цээжинд үлдсэн маань энэ.” Үүнээс үзэхэд зохиолч Д. Цэнджавын эх Долгор ардын сайхан зүйр цэцэн үг болон ухаант мэргэн үгсээр үр хүүхдүүдээ хүмүүжүүлж байсан гэдгийг харж болно. Туужийн төгсгөлд зохиолч “Буурал ээжийнхээ хөлийг юугаар дулаацуулсан билээ” гэсэн өчил хоргоо үгэнд эрхэм та өөрөө хариулаад үзээрэй... гомдолгүй... гэх үр хэр олон гарах бол доо? энэ мэлтгэр тэнгэрийн дор...” гэжээ. Бид ч бас тэрхүү эрхэм үгийг уншигч танаа хаяглаж байна. Хэн ч байсан тэрхүү асуултад хариулаад үзээрэй, эс бөгөөс зүгээр л хариулах гэж оролдоод үзээрэй гэдгийг онцлог тэмдэглэмээр байна. Энэ мэт туужид хүний сэтгэлийн гүнд нэгийг бодогдуулахаар, хүний ертөнцийг танин мэдэж, ухаарах гэсэн нэгдмэл ба зээлдмэл тэмүүлэл, элдэв янзын үзэгдэл, юмс, үүний тухай эцэс төгсгөлгүй мэт ухаарлуудыг зохиолчийн авьяас чадвар давхар шүүн тунгааж боловсруулсан нь өвөрмөц болжээ.

Дүгнэлт

1. До. Цэнджавын туужууд нь дотоод төрөл зүйлийн хувьд баяжин хөгжихдөө нэгд сэтгэл зүйн тууж, хоёрт түүхэн тууж, гуравт эссе тууж гэсэн зүйл ангилалд хамрагдахаар байна. Зохиолчийн сэтгэл зүйн туужуудийг ажиглахад голдуу ёс зүйн асуудал хөндөхдөө дүрийнхээ дотоод сэтгэлзүйтэй холбон хүний сэтгэлийг жихүүцүүлэн огшуулж, айдас хүйдэс төрүүлж, харамсал гашуудал, гэмшил ухаарлыг нэгэн зэрэг огшуулж байдаг. Энэхүү өвөрмөц өнгө аяс нь баатруудынхаа хувь бодгаль ертөнцийн зөрчилийг бодитой харуулахад чухал нөлөө үзүүлдэг байна.

2. Түүхэн туужууд нь болсон бодит үйл явдал баримтаар баяжигдахдаа өгүүлэмжийн хувьд хэт нуршуу бус зохиолчийн мөшгисөн түүх, өнгөрснөө эргэн сануулах, ухааруулах сэжмээр илэрхийлэгдсэн байдгаараа өвөрмөц юм.

3. Эсээ туужууд нь голдуу ямар нэг шалтгаан хийгээд асуудлын талаар бодол эргэцүүлэмж, таамаглалыг шингээсэн, товч, гүн утга санааг илэрхийлсэн байна.

Ном зүй

1. Батсайхан. О. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ. Улаанбаатар: 2013. 404 тал.

2. Батсайхан О. Монголын сүүлийн хаан Богд Жавзандамба Хутагт. Улаанбаатар: 2008. 290–292 тал.

3. Галбаатар. Д. Уран зохиолын онолын ойлголт нэр томъёоны тайлбар толь. Токио: 2002. 540 тал.

4. ХХ зууны монголын уран зохиол судлалын дээж бичиг // С. Дулам Түүхэн ба баримтат зохиолыг ургуулан бодохуйд. Улаанбаатар: 2007. 195 тал.

5. Кимбалл Ж. Д. Дайчин бүсгүй // Архелогийн олдвороор олдсон түүхийн дурсгалууд. Улаанбаатар: 2002. 223–226 тал.

6. Хатан цадиг // До. Цэнджав. Суудал өнцөгдсөн сэнтий. Улаанбаатар: 2014. 45 тал.

7. Утга зохиолын судлал шинжлэл // До. Цэнджавын шинжлэл. Улаанбаатар: 2017. 7 тал.
8. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар: 1966. 329 тал.
9. Цэнд-Аюуш Ши. Монгол тууж. Улаанбаатар: 1981. 7–8 тал.
10. Яндий П. Уран зохиол ба ёс зүй. Улаанбаатар: 2016. 115 тал.

Эх зохиолууд

1. Цэнджав До. Гүн тайгын манан: шилмэл туужууд. Улаанбаатар: 2017. 78 тал.
2. Цэнджав До. Маргааш л дайн эхэлчих юм шиг 1080 хоног минь // Тэнгэрт хальсан тоос: шилмэл туужууд. Улаанбаатар: 2014. 613 тал.
3. Цэнджав До. Хөх жавар // Тэнгэрт хальсан тоос: шилмэл туужууд. Улаанбаатар: 2014. 12 тал.
4. Цэнджав До. Тэнгэрт хальсан тоос // Тэнгэрт хальсан тоос: шилмэл туужууд. Улаанбаатар: 2014. 155–156 тал.
5. Цэнджав До. Тал сар // Тэнгэрт хальсан тоос: шилмэл туужууд. Улаанбаатар: 2014. 590–591 тал.
6. Цэнджав До. Цахарын хар шуурга // Тэнгэрт хальсан тоос: шилмэл туужууд. Улаанбаатар: 2014. 245-тал.

2025 оной майн арбан зургаанда статья редакцида ороо; 2025 оной майн хорин зургаанда зүбшөөл гараа; 2025 оной майн гушанда хэблэлдэ ороо.

Issues of Genre Classification in the Novellas of D. Tsendzhav

Yandii Purevsurengiin

PhD in Philology,

Teacher of Mongolian Literature

School of Social Sciences and Humanities

Mongolian National University of Education

Sukhbaatar District 14, Ulaanbaatar 14191, Mongolia

yandii@msue.edu.mn

Abstract. The article studies the genre-specific features of the novellas by Mongolian writer Dolgoryn Tsendzhav. D. Tsendzhav, an Honored Cultural Worker and recipient of the Mongolian Writers' Union Award, the D. Natsagdorj Prize, and the S. Buyannemekh Prize, is one of the well-known contemporary writers who has established his place in Mongolian prose. His works began appearing in print in the 2000s: the first collection of short stories and novellas *Blue Wind* was published in 1995, followed by the novellas *Mist of the Taiga* (1996), *The Black Hurricane of Tsakhar* (2007), *My 1080 Days...* (2007), *Throne in the Corner* (2013), *Dust Drifted Across the Sky* (2014), *Crescent Moon* (2014), and others. Among them, the novella *Blue Wind* drew the attention of Mongolian researchers (Khishig-sukh, P. Batkhuyag, Ch. Chimegbaatar, and P. Yandii). In 2016, researcher Ch. Chimegbaatar wrote an article titled *Peculiarities of the Narrative Structure of Two Novellas*, thereby defining the narrative specifics of *Blue Wind* and *Dust Drifted Across the Sky*. In the present article, the author aims to identify the genre characteristics of all novellas by D. Tsendzhav, both writer and scholar.

Keywords: genre, psychological novella, historical novella, essay-novella, development, image.

For citation

Purevsurengiin Ya. Issues of Genre Classification in the Novellas of D. Tsendzhav. Buryat Language and Literature in School. 2025; 2: 82–93 (In Mong.)

The article was submitted 16.05.2025; approved after reviewing 26.05.2025; accepted for publication 30.05.2025.